



# ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 26 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2026 оны  
төсвийн хуваарь батлах зөвлөмж гаргах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8.4 дэх заалт, Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3.1, 4.6 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 5.1, 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.2026 оны төсвийн хуваарийн төслийг хэлэлцээд, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2026 оны төсвийн хуваарийг хавсралтаар батлахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад зөвлөсүгэй.

2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2026 оны батлагдсан төсвийн хүрээнд санхүүжилтийг хуваарилан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа (хөтөлбөр)-ны хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржанд, хэрэгжилтийг хангаж, төсвийн гүйцэтгэлийг сар бүр тайлагнаж ажиллахыг холбогдох байгууллагууд, Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, дүүргийн зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Т.АУБАКИР